



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2007 оны 11 сарын 7 өдөр

Дугаар 555

Улаанбаатар хот

**“Өргөө зочид буудал” нийслэлийн өмчит
үйлдвэрийн газрыг татан буулгаж, нийслэлийн
өмчийн оролцоотой хамтарсан компани
байгуулах тухай**

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 78 дугаар зүйлийн 2 дугаар заалт, “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, “Хөдөлмөрийн тухай” хуулийн 40 дүгээр зүйлийн 40.9.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2007 оны 188 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. “Өргөө зочид буудал” нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг 2007 оны 11 дүгээр сарын 09-ний өдрөөр тасалбар болгон татан буулгасугай.

Хоёр. “Өргөө зочид буудал” нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захирал Ж.Энхжаргалыг 2007 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

Гурав. Татан буулгах ажлыг зохион байгуулах комиссыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Дөрөв. Татан буугдаж байгаа байгууллагын авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар барагдуулж, хаалтын балансыг 2007 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэхийг татан буулгах комисс /Ж.Эрдэнэбаатар/, “Өргөө зочид буудал” нийслэлийн өмчит үйлдвэрийн газар /Ж.Энхжаргал/-т даалгасугай.

Тав. “Өргөө зочид буудал” нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагааны хүрээг өргөтгөх, үр ашгийг дээшлүүлэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор “Хар дун” хязгаарлагдмал хариуцлагатай компаниар хөрөнгө оруулалт хийлгэн, нийслэлийн өмчийн 25 хувь, “Хар дун” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 75 хувийн оролцоотой хамтарсан компани байгуулах ажлыг зохион байгуулахыг нийслэлийн Өмчийн харилцааны газар /М.Ганбаатар/-т зөвшөөрсүгэй.

Зургаа. Нийслэлийн өмчийн оролцоотой “Дун-Өргөө” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гэрээг хоёрдугаар хавсралтаар, дүрмийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Долоо. "Өргөө зочид буудал" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын "Дүнжингарав-Өргөө" зочид буудлын эзэмшил газрын хязгаарлалтын бүс, газрын хэмжээг нарийвчлан тогтоож, газрын маргаантай холбоотой зөрчлийг арилгаж, холбогдох шийдвэр гаргахыг нийслэлийн Газрын алба /Б.Төмөрхуяг/, нийслэлийн Өмчийн харилцааны газар /М.Ганбаатар/-т тус тус үүрэг болгосугай.

Найм. Шинээр багуулагдах компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд нийслэлийн төлөөлөгчийг оролцуулан, үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллахыг нийслэлийн Өмчийн харилцааны газар /М.Ганбаатар/-т үүрэг болгосугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БОГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц.БАТБАЯР



Нийслэлийн Засаг Даргын 2007 оны
11.8.2007 сарын 7 өдрийн 335 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

"Өргөө зочид буудал" Нийслэлийн өмчит үйлдвэрийн
газрыг татан буулгах комисс

Комисын дарга:	Ж.Эрдэнэбаатар	Нийслэлийн Өмчийн харилцааны өмчийн бодлого ашиглалт, төлөөллийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Т.Оюунсувд	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын өмч хувьчлалын хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд:	Ж.Сувданзаяа	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын төлөөллийн хэлтсийн мэргэжилтэн
	Б.Бүрэнцэцэг	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын хяналт мониторингийн хэлтсийн мэргэжилтэн
	Ж.Шүрэнцэцэг	"Өргөө зочид буудал" НӨҮГ-н нягтлан бодогч
	Д.Энхээ	"Өргөө зочид буудал" НӨҮГ"-н нярав

Нийслэлийн Засаг Даргын 2007 оны
11-р сарын 7 өдрийн 555 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР,
/НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР/
"ХАР ДУН" ХХК-ИЙН ХАМТАРСАН "ДУН-ӨРГӨӨ"
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ГЭРЭЭ

Ерөнхий зүйл.

Монгол улсын "Иргэний хууль", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай", "Компанийн тухай хууль" зэрэг холбогдох хууль тогтоомжуудыг удирдлага болгон нэг талаас Нийслэлийн Засаг Даргын тамгын газар /Нийслэлийн Өмчийн харилцааны газар/ /цаашид "А" тал гэх/, нөгөө талаас "Хар дун" ХХК /цаашид "Б" тал гэх/ цаашид хамтад нь "Талууд" гэх хамтарсан хязгаарлагдмал хариуцлагатай компани /цаашид компани гэх/ байгуулах зорилгоор доорхи зүйлийг харилцан тохиролцов.

Нэгдүгээр зүйл. Компанийн зорилго, үйл ажиллагаа

Компани нь доорхи үйл ажиллагааг явуулах зорилготой. Үүнд:

- 1.1. Амралт, аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэх зорилгоор зочид буудал, зоогийн газар бүхий амралт, аялал жуулчлалын төв байгуулан ажиллуулах
- 1.2. Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаа
- 1.3. Монгол улсын хууль тогтоомжид хориглоогүй бусад үйл ажиллагаа эрхлэх

Хоёрдугаар зүйл. Үүсгэн байгуулагч талууд

2.1. Энэхүү гэрээний оролцогч талууд нь

"А" талаас Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
/Нийслэлийн өмчийн харилцааны газар/

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот-46

Сүхбаатарын талбай-11

/Чингэлтэй дүүрэг

Жигжиджавын гудамж-2/

"Б" талаас "Хар дун" ХХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот

Баянгол дүүрэг, 2-р хороолол

Энхтайваны оргон чолоо-3

Гуравдугаар зүйл. Компанийн нэр, байршил, эрх хэмжээ

3.1. Компанийн оноосон нэр нь

-монголоор "Дун-Өргөө" ХХК

-англиар "DUN-URGUU" Co.Ltd гэж нэрлэгдэх бөгөөд Улаанбаатар хотноо байрлана.

3.2. Компанийн албан ёсны хаяг:

Монгол улс, Улаанбаатар хот
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо
Жуулчны гудамж, М-100-р байр, 6-р орц
Утас: 313726, 328388

3.3. Компани нь Улсын бүртгэлийн албанд бүртгүүлснээр Монгол улсын хуулийн дагуу хуулийн этгээдийн эрхтэй болох бөгөөд уг өдрөөс эхлэн аж ахуйн үйл ажиллагаа явуулах эрх эдэлнэ. Компанийн хуулийн этгээд болсон өдрийг уг компани үүсгэн байгуулагдсан өдөр гэж үзнэ.

3.4. Компани нь өөрийн нэрийн өмнөөс гадаад, дотоодын байгууллагатай гэрээ хэлцэл байгуулах, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдлэх, үүрэг хүлээх, шүүхэд нэхэмжлэгч болон хариуцагчаар оролцох эрхтэй.

3.5. Компани нь энэхүү гэрээнд оролцогч талуудын хүлээсэн үүрэг, хариуцлагыг хүлээхгүй ба талууд нь компанийн хүлээсэн үүрэг, хариуцлагыг хүлээхгүй.

Дөрөв. Компани үүсгэн байгуулагч талуудын эрх, үүрэг

4.1. "А" тал дараахь үүрэгтэй байна.

4.1.1. Компанийг улсын бүртгэлд бүртгүүлэх үед дүрмийн санг "Компанийн тухай хууль"-ийн дагуу бүрдүүлэх

4.1.2. Шинээр байгуулагдах компанид үйл ажиллагаа явуулахад шаардлагатай зөвшөөрөл, дүгнэлтүүдийг гаргаж өгөх

4.1.3. Компани байгуулахтай холбогдуулан "Өргөө зочид буудал" НӨҮГ-н үйл ажиллагааг хамтарсан компани байгуулагдах өдрөөс өмнө зогсоож, шинээр өөрчлөн байгуулагдсан компанид өмч хөрөнгө болон үйл ажиллагаа явуулах эрхийг шилжүүлэх

4.1.4. Шинээр үүсгэн байгуулагдсан компани болон "Б" талыг шаардлагатай холбогдох хууль тогтоомж болон бусад мэдээллээр хангах

4.1.5. Гэрээнд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлд болон компанийн удирдлагад оруулах этгээдийн талаар санал оруулах

4.2. "Б" тал дараахь үүрэгтэй байна.

4.2.1. Компанийг улсын бүртгэлд бүртгүүлэх үед дүрмийн санг "Компанийн тухай хууль"-ийн дагуу бүрдүүлэх

4.2.2. Гэрээнд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлд болон компанийн удирдлагад оруулах этгээдийн талаар санал оруулах

4.2.3. Компанид ажиллах боловсон хүчнийг бэлтгэх, сургахад дэмжлэг үзүүлэх

4.3. "Талууд" дараахь эрх, үүрэгтэй байна.

4.3.1. Үүсгэн байгуулагч талуудын байгуулсан Гэрээ, компанийн дүрмийн үндсэн дээр гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор холбогдох байгууллагад шинээр үүсгэн байгуулагдсан компанийг Улсын бүртгэлд бүртгүүлж, данс нээлгэх, тамга тэмдэг хийлгэх зэрэг бусад бэлтгэл ажлыг хангах

4.3.2. "Дун-Өргөө" ХХК-ийг хамтран хөрөнгө оруулж үүсгэн байгуулах

4.3.3. Компанид шаардлагатай материал, түүхий эд, машин тоног төхөөрөмж, бусад зүйлээр хангахад дэмжлэг үзүүлэх

4.3.4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон удирдлагыг бүрдүүлэх

4.3.5. Компанийн өөрт ногдох ногдол ашгийг авах, нөгөө талын зөвшөөрлөөр компанийн дүрмийн санд хөрөнгө дахин оруулах

Тавдугаар зүйл. Дүрмийн сан

5.1. Компанийн дүрмийн сан нь оролцогч талуудын оруулсан хувь хөрөнгөнөөс бүрдэх бөгөөд нэг бүр нь 10000 /арван мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 187200 /нэг зуун наян долоон мянга хоёр зуун/ ширхэг хувьцаа /цаашид хувьцаа/ -наас бүрдэнэ.

-“А” талаас компанийн дүрмийн санд оруулах хөрөнгө нийт хувьцааны 25% буюу 468.000.000 /дөрвөн зуун жаран найман сая/ төгрөг

-“Б” талаас компанийн дүрмийн санд оруулах хөрөнгө нийт хувьцааны 75% буюу 1.404.000.000 /нэг тэрбум дөрвөн зуун дөрвөн сая/ төгрөг байна.

5.2. Үүсгэн байгуулагч талууд компанид оруулах өөрийн хувь хөрөнгийг дараах байдлаар оруулна. Үүнд:

-“А” тал компанийн өөрийн хөрөнгийн нийт 25% буюу 468.000.000 төгрөгийн үнийн дүнтэй тэнцэх хөрөнгийг /дахин үнэлэгдсэн үнэ болох/ "Өргөө зочид буудал" НӨҮГ-н нийт хөрөнгийн хууль ёсны өмчлолийг шилжүүлнэ. Барилга байгууламжийн оршин байгаа газрыг ашиглах эрхийн хамт шилжүүлнэ.

-“Б” тал компанийн өөрийн хөрөнгийн 75% буюу 1.404.000.000 төгрөгийн үнийн дүнтэй тэнцэх хөрөнгийг гаргана. Үүнд:

а/ Барилга байгууламжид оруулах хөрөнгө оруулалтанд 872.000.000 /найман зуун далан хоёр сая/ төгрөг

б/ Тоног төхөөрөмнд оруулах хөрөнгө оруулалт 325.000.000 /гурван зуун хорин таван сая/ төгрөг

в/ Тавилга хэрэгсэлд оруулах хөрөнгө оруулалт 207.000.000 /хоёр зуун долоон сая/ төгрөг байна

5.3. Дүрмийн сангийн хэмжээг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр өөрчилж болох ба гэрээнд нэмэлт өөрчлөлт хийх тухайгаа 14 хоногийн дотор Улсын бүртгэлийн албанд мэдэгдэж өөрчлөлт хийлгүүлнэ.

5.4. Компани байгуулагдах үед талуудаас дүрмийн санд оруулсан хувь хөрөнгийн хэмжээг нотолсон гэрчилгээг уг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл талуудад олгоно.

5.5. Компанийн хувьцаа эзэмшигчид нь компанийн бусад хувьцаа эзэмшигчийн худалдах хувьцаа, тэдгээрийн худалдан авах эрхийн бичгийг гурав дахь этгээдэд санал болгох үнээр эзэмшиж байгаа хувьцааны тоонд хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.

Зургадугаар зүйл. Компанийн удирдлага

6.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувь нийлүүлэгчдийн хурал байна.

6.2. Хувь нийлүүлэгчдийн хурлын чөлөөт цагт компанийг 5 /таван/ гишүүн бүхий Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ удирдах бөгөөд ТУЗ нь жилд хоёроос доошгүй удаа хуралдана. Ээлжит бус хурлыг хэзээ ч зарлан хуралдуулж болно.

6.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 5 гишүүний 1 гишүүнийг Нийслэлийн засаг даргын тамгын газар, Нийслэлийн өмчийн харилцааны газар, 4 гишүүнийг "Хар дун" ХХК-иас төлөөлөлтэй байна.

6.4. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг ТУЗ-аас томилосон гүйцэтгэх захирал удирдан явуулна.

6.5. Гүйцэтгэх захирал нь компанийн үйл ажиллагааг компанийн гэрээ, дүрэм, ТУЗ-н хурлын шийдвэрээр олгосон эрх хэмжээний хүрээнд удирдан зохион байгуулна.

6.6. Компанийн гүйцэтгэх захирал нь компанийн хувь нийлүүлэгчдийн баталсан хөлсөөр ажиллах гэрээний нөхцөлүүдийн дагуу ажил үүргээ гүйцэтгэх бөгөөд уг гэрээнд захиралын эрх үүрэг, цалин хөлс урамшууллын хэмжээг заасан байна.

6.7. Гүйцэтгэх захирал нь компанийн ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх, цалин хөлс, шагнал урамшил, тэтгэвэр тэтгэмжийн асуудал зэрэг хөдөлмөрийн бусад харилцааг "Хөдөлмөрийн хууль" болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.

Долдугаар зүйл. Компанийн бүртгэл, тайлан ба хяналт

7.1. Компанийн санхүүгийн жил нь 1 дүгээр сарын 1-нээс эхлэн /эхний жилийн хувьд байгуулагдсан өдрөөс/ 12 дугаар сарын 31-нд /татан буугдсан болон өөрчлөн зохион байгуулагдсан бол шийдвэр гарсан өдрөөс/ дуусна.

7.2. Компани нь хуулиар тогтоосон журмын дагуу нягтлан бодох бүртгэл хотлон, санхүүгийн тайлан гаргаж, хувь нийлүүлэгч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Тайлангийн үнэн зөвийг компанийн гүйцэтгэх удирдлага хариуцна.

7.3. Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн санхүүгийн үй ажиллагааг хянах хөндлөнгийн аудитын компанийг томилно.

7.4. Компанийн жилийн санхүүгийн тайланг баталгаажуулахын тулд аудитор ээлжит шалгалт хийнэ. Ээлжит бус шалгалтыг ТУЗ-ийн шаардлагаар хэдийд ч хийж болно. Аудиторын шалгалтын хөлсийг компани хариуцан төлнө.

7.5. Компанид хувь оруулагч талууд дүрмийн санд оруулсан хувь хөрөнгийн хэмжээгээр ашигтай ажилласан бол ногдол ашгийг ТУЗ-н шийдвэрээр олгоно.

7.6. Компани нь албан татвар, хураамж, шимтгэл бусад холбогдох төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төлнө.

Наймдугаар зүйл. Татан буулгах

8.1. Компанийг хувь нийлүүлэгчдийн болон шүүхийн шийдвэрээр татан буулгаж болно. Үүнд:

8.1.1. Компани шүүхийн дор дурдсан үндэслэлээр татан буугдана:

1/ Дампуурсан

2/ нэг ч гишүүн үлдээгүй

3/ хуулинд заасан бусад үндэслэл

8.1.2. Компанийг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр дор дурдсан үндэслэлээр татан буулгана. Үүнд:

1/ аль нэг тал нь энэхүү гэрээнд заасны дагуу компанийн дүрмийн санд өөрийн хувь хөрөнгөө нийлүүлж чадахгүй байдалд 1 /нэг/ жил болсон бол

2/ компани алдагдалтай ажиллаж байгаагийн улмаас цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжгүй болсон

3/ аль нэг тал энэхүү гэрээ болон дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй болсон

4/ талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр

8.2. Компанийг татан буулгах тохиолдолд Татан буулгах комиссыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилно.

8.3. Татан буулгах комисс нь өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогыг хувь нийлүүлсэн хэмжээгээр хувиарлана.

8.4. Татан буулгах комисс нь өр төлбөрийг барагдуулсаны дараа дуусгалтын баланс гаргана.

Есдүгээр зүйл. Маргаан таслах

9.1. Энэхүү гэрээг зөрчсөнөөс болон түүнийг хэрэглэх, тайлбарлах хүчинтэй хугацааг тогтоох, сунгах, цуцлахтай холбогдсон аливаа маргаан зөрчилдөөн, гомдлын шаардлагыг талууд эвийн журмаар зөвлөлдөн шийдвэрлэх ба тохиролцоонд хүрэхгүй бүл шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

Аравдугаар зүйл. Бусад зүйл

10.1. Энэхүү гэрээний оролцогч талууд нь гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох ба эдгээр энэ нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болно.

10.2. Энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

Энэхүү гэрээг 2007 оны сарын өдөр Улаанбаатар хотноо байгуулав.

Гэрээ байгуулсан:

"А" талыг төлөөлж:

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц.БАТБАЯР

"Б" талыг төлөөлж:

"ХАР ДУН" ХХК-Н
ЗАХИРАЛ

Б.ХУЯГ

Нийслэлийн Засаг Даргын 2007 оны
11 сарын 7-ны өдрийн 535 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР,
/НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР/
"ХАР ДУН" ХХК-ИЙН ХАМТАРСАН "ДУН-ӨРГӨӨ"
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ

Монгол улсын "Иргэний хууль", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай", "Компанийн тухай хууль" зэрэг холбогдох хууль тогтоомжуудыг удирдлага болгон нэг талаас Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар /Нийслэлийн Өмчийн харилцааны газар/ /цаашид "А" тал гэх/, нөгөө талаас "Хар Дун" ХХК /цаашид "Б" тал гэх/ хамтарсан хязгаарлагдмал хариуцлагатай компани /цаашид компани гэх/-ийн дүрэм нь "Дун-Өргөө" Хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах тухай 2007 оны ... дугаар ... сарын ... өдөр талуудын байгуулсан гэрээний салшгүй хэсэг болно.

Нэгдүгээр зүйл. Компанийн зорилго, үйл ажиллагаа

Компани нь доорхи үйл ажиллагааг явуулах зорилготой. Үүнд:

- 1.1.1. Амралт, аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэх зорилгоор зочид буудал, зоогийн газар бүхий амралт, аялал жуулчлалын төв байгуулан ажиллуулах
- 1.1.2. Үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх
- 1.1.3. Монгол улсын хууль тогтоомжид хориглоогүй бусад үйл ажиллагаа

Компани нь дараах үндсэн үйл ажиллагаа эрхэлнэ. Үүнд: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 2-р хорооны нутаг дэвсгэрт орших зочид буудал, зоогийн газрын үйлчилгээ, Хан-Уул дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт орших "Дүнжингарав-Өргөө" зочид буудлын үйл ажиллагааг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр ажил үйлчилгээ явуулна.

Хоёрдугаар зүйл. Үүсгэн байгуулагч талууд

2.1. Үүсгэн байгуулагч талууд нь

"А" талаас Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
/Нийслэлийн өмчийн харилцааны газар/

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот-46
Сүхбаатарын талбай-11
/Чингэлтэй дүүрэг
Жигжиджавын гудамж-2/
"Б" талаас "Хар дун" ХХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот
Баянгол дүүрэг, 2-р хороолол
Энхтайваны өргөн чөлөө -3

Гуравдугаар зүйл. Компанийн нэр, байршил, эрх хэмжээ

3.1. Компанийн оноосон нэр нь

-монголоор "ДУН-ӨРГӨӨ" ХХК
-англиар "DUN-URGUU" Co.Ltd гэж нэрлэгдэх бөгөөд Улаанбаатар хотноо байрлана.

3.2. Компанийн албан ёсны хаяг:

Монгол улс, Улаанбаатар хот
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо
Худалдааны гудамж М-100 байр 6-р орц
Утас: 313726, 328388

3.3. Компани нь Улсын бүртгэлийн албанд бүртгүүлснээр Монгол улсын хуулийн дагуу хуулийн этгээдийн эрхтэй болох бөгөөд уг өдрөөс эхлэн аж ахуйн үйл ажиллагаа явуулах эрх эдэлнэ. Компанийн хуулийн этгээд болсон өдрийг уг компани үүсгэн байгуулагдсан өдөр гэж үзнэ.

3.4. Компани нь өөрийн нэрийн өмнөөс гадаад, дотоодын байгууллагатай гэрээ хэлцэл байгуулах, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдлэх, үүрэг хүлээх, шүүхэд нэхэмжлэгч болон хариуцагчаар оролцох эрхтэй.

3.5. Компани нь өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллах бие даасан хуулийн этгээд мөн.

3.6. Компани нь өөрийн нэр бүхий тамга тэмдэг, бэлэгдэл, албан бичгийн хэвлэмэл хуудас, банкинд харилцах данстай байна.

Дөрөв. Компанийн удирдлага зохион байгуулалт, үүсгэн байгуулагчийн эрх

4.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувь нийлүүлэгчдийн хурал байна.

4.2. Хувь нийлүүлэгчдийн хурлын чөлөөт цагт компанийг 5 /таван/ гишүүн бүхий Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ удирдана. Төлөөлөн удирдах зөвлөлийн 5 гишүүний 1 гишүүнийг Нийслэлийн засаг даргын тамгын газар, Нийслэлийн өмчийн харилцааны газар, 4 гишүүнийг "Хар дун" ХХК-иас томилно.

4.3. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг ТУЗ-аас томилсон гүйцэтгэх захирал ба түүний баг удирдан явуулна.

4.4. ТУЗ нь компанийн удирдах дээд байгууллагын хувьд компанийн үйл ажиллагаа, удирдлага, хяналт шалгалтын бүх асуудлыг зохицуулан чиглүүлнэ. ТУЗ нь асуудлыг дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

4.5. Үүсгэн байгуулагчид өөрийн талаас томилсон ТУЗ-н гишүүнийг солих эрхтэй. Энэ тухайгаа нөгөө талд болон компанийн захиргаанд албан бичгээр мэдэгдэнэ.

4.6. ТУЗ-н хурал хийх тов, хэлэлцэх асуудлыг ТУЗ-н гишүүдэд хурал эхлэхээс 7 хоногийн өмнө албан бичгээр мэдэгдэнэ.

4.7. ТУЗ-н аль нэг гишүүн хуралд оролцох боломжгүй бол өөрийн оронд итгэмжлэгдсэн хүнээ оролцуулж болно. ТУЗ-н гишүүний итгэмжлэгдсэн этгээд

түүнийг төлөөлж нэг удаа санал өгөх эрхтэй бөгөөд хэрэв итгэмжлэгдсэн этгээд өөрөө ТУЗ-н гишүүн бол хоёр саналын эрх эдэлнэ.

4.8. Гүйцэтгэх захирал нь компанийн үйл ажиллагааг компанийн гэрээ, дүрэм, ТУЗ-н хурлын шийдвэрээр олгосон эрх хэмжээний хүрээнд удирдан зохион байгуулна.

4.5. Компанийн гүйцэтгэх захирал нь компанийн хувь нийлүүлэгчдийн баталсан хөлсөөр ажиллах гэрээний нөхцөлүүдийн дагуу ажил үүргээ гүйцэтгэх бөгөөд уг гэрээнд захиралын эрх үүрэг, цалин хөлс урамшууллын хэмжээг заасан байна.

4.6. Гүйцэтгэх захирал нь компанийн дотоод журам, бүтэц, орон тоо, цалингийн хэмжээ, урамшууллын журмыг тогтоож мөрдүүлэх ба ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх, тэтгэвэр тэтгэмжийн асуудал зэрэг хөдөлмөрийн бусад харилцааг "Хөдөлмөрийн хууль" болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.

Тавдугаар зүйл. Компанийн үйл ажиллагааны эрх хэмжээ

5.1. Компани нь өмч хөрөнгө болон өмч хөрөнгийн бусад эрх эдлэх, үүрэг хүлээх, түүнчлэн шүүх, арбитрайн байгууллагад нэхэмжлэгч ба хариуцагчаар оролцоно.

5.2. Компани нь өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, компанийн хуульд заасан эрх хэмжээний дотор үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмшиж ашиглана.

5.3. Нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, бизнес төлөвлөгөө, төсөл боловсруулах, нягтлан бодох бүртгэлийн болон бусад санхүүгийн холбогдолтой хууль, дүрэм, заавар журам, норм нормативийг мөрдүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.

5.4. Компани нь өмч хөрөнгийн тооллого тооцоо бүртгэл хөтлөлтийг зохих хууль дүрмийн дагуу хотолж, эд хөрөнгө шинээр олж авах, ашиглалтаас хасах, түрээслүүлэхдээ ТУЗ-н шийдвэрийг баримтална.

Зургадугаар зүйл. Өмч хөрөнгө, санхүүгийн бүртгэл, хяналт

6.1. Компанийн өмч хөрөнгө, санхүүгийн тайланг Монгол улсын "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хөтлөн явуулна.

6.2. Компанийн санхүүгийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 12 дугаар сарын 31-ны өдөр дуусна. Санхүүгийн анхны жил нь байгуулагдсан өдрөөс эхэлж, хуанлийн 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болох ба санхүүгийн сүүлчийн жил нь татан буугдсан өдрөөр дууссанд тооцно.

6.3. Компани нь хуулиар тогтоосон журмын дагуу анхан шатны баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан тэнцэлийг улирлаар гаргаж, хувь нийлүүлэгч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Тайлангийн үнэн зөвийг компанийн гүйцэтгэх удирдлага хариуцна.

6.4. Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн санхүүгийн үйл ажиллагааг хянах хөндлөнгийн аудитын компанийг томилно.

6.5. Компанийн жилийн санхүүгийн тайланг баталгаажуулахын тулд аудитор ээлжит шалгалт хийнэ. Ээлжит бус шалгалтыг ТУЗ-ийн шаардлагаар хэдийд ч хийж болно. Аудиторын шалгалтын хөлсийг компани хариуцан төлнө.

6.6. Компанид хувь оруулагч талууд дүрмийн санд оруулсан хувь хөрөнгийн хэмжээгээр ашигтай ажилласан бол ногдол ашгийг ТУЗ-н шийдвэрээр олгоно.

6.7. Компани нь албан татвар, хураамж, шимтгэл бусад холбогдох төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төлнө.

Долдугаар зүйл. Дүрмийн сан

7.1. Компанийн дүрмийн сан нь оролцогч талуудын оруулсан хувь хөрөнгөнөөс бүрдэх бөгөөд нэг бүр нь 10000 /арван мянган/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 187200 ширхэг хувьцаа /цаашид хувьцаа/ -наас бүрдэнэ.

-“А” талаас компанийн дүрмийн санд оруулах хөрөнгө нийт хувьцааны 25% буюу 46800 /дөчин зургаан мянга найман зуу/ ширхэг хувьцаа буюу 468.000.000 /дөрвөн зуун жаран найман сая/ төгрөг

-“Б” талаас компанийн дүрмийн санд оруулах хөрөнгө нийт хувьцааны 75% буюу 140400 /нэг зуун дөчин мянга дөрвөн зуун/ ширхэг хувьцаа буюу 1.404.000.000 /нэг тэрбум дөрвөн зуун дөрвөн сая/ төгрөг байна.

7.2. Үүсгэн байгуулагч талууд компанид оруулах өөрийн хувь хөрөнгийг дараах байдлаар оруулна. Үүнд:

-“А” тал компанийн өөрийн хөрөнгийн нийт 25% буюу 468.000.000 төгрөгийн үнийн дүнтэй тэнцэх хөрөнгийг дахин үнэлэгдсэн үнэ болох “Өргөө зочид буудал” НӨҮГ-н нийт хөрөнгийн хууль ёсны өмчлөлийг шилжүүлнэ. Барилга байгууламжийн оршин байгаа газрыг ашиглах эрхийн хамт шилжүүлнэ.

-“Б” тал компанийн өөрийн хөрөнгийн 75% буюу 1.404.000.000 төгрөгийн үнийн дүнтэй тэнцэх хөрөнгийг гаргана. Үүнд:

а/ Барилга байгууламжид оруулах хөрөнгө оруулалтанд 872.000.000 /найман зуун далан хоёр сая/ төгрөг

б/ Тоног төхөөрөмжөөр оруулах хөрөнгө оруулалт 325.000.000 /гурван зуун хорин таван сая/ төгрөг

в/ Тавилга хэрэгсэлд оруулах хөрөнгө оруулалт 207.000.000 /хоёр зуун долоон сая/ төгрөг байна.

7.3. Дүрмийн сангийн хэмжээг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр өөрчилж болох ба гэрээнд нэмэлт өөрчлөлт хийх тухайгаа 14 хоногийн дотор Улсын бүртгэлийн албанд мэдэгдэж өөрчлөлт хийлгүүлнэ.

7.4. Компани байгуулагдах үед талуудаас дүрмийн санд оруулсан хувь хөрөнгийн хэмжээг нотолсон гэрчилгээг уг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл талуудад олгоно.

7.5. Компанийн хувьцаа эзэмшигчид нь компанийн бусад хувьцаа эзэмшигчийн худалдах хувьцаа, тэдгээрийн худалдан авах эрхийн бичгийг

гурав дахь этгээдэд санал болгох үнээр эзэмшиж байгаа хувьцааны тоонд хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй

*Наймдугаар зүйл. Үүсгэн байгуулах, өөрчлөн зохион байгуулах,
татан буулгах*

8.1. Компанийг хувь нийлүүлэгчдийн болон шүүхийн шийдвэрээр татан буулгаж болно. Үүнд:

8.1.1. Компани шүүхийн дор дурдсан үндэслэлээр татан буугдана.

1/ Дампуурсан

2/ нэг ч гишүүн үлдээгүй

3/ хуулинд заасан бусад үндэслэл

8.1.2. Компанийг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр дор дурдсан үндэслэлээр татан буулгана. Үүнд:

1/ аль нэг тал нь энэхүү гэрээнд заасны дагуу компанийн дүрмийн санд өөрийн хувь хөрөнгөө нийлүүлж чадахгүй байдалд 1 /нэг/ жил болсон бол

2/ компани алдагдалтай ажиллаж байгаагийн улмаас цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжгүй болсон

3/ аль нэг тал энэхүү гэрээ болон дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй болсон

4/ талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр

8.2. Компанийг татан буулгах тохиолдолд Татан буулгах комиссыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилно.

8.3. Татан буулгах комисс нь өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогыг хувь нийлүүлсэн хэмжээгээр хувиарлана.

8.4. Татан буулгах комисс нь өр төлбөрийг барагдуулсаны дараа дуусгалтын баланс гаргана.

Есдүгээр зүйл. Хариуцлага

9.1. Компани нь Монгол улсын хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлэх явцад буруу шийдвэр гаргаж, бусдад хохирол учруулсан нь шүүхээр тогтоогдсон бол холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

9.2. ТУЗ болон компанийн захирал нь эрх мэдлээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглаж компанидаа хохирол учруулсан бол уг хохиролыг өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцана.

Аравдугаар зүйл. Бусад зүйл

10.1. Энэхүү дүрэмд ТУЗ-ийн шийдвэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох ба эдгээр нэмэлт өөрчлөлт нь дүрмийн салшгүй хэсэг болно.

10.2. Энэхүү дүрэмд өөрчлөлт оруулсан тухай бүр хувь нийлүүлэгчид болон зохих эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.